

**РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025.04.30

№ ХЭХ-25/01

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.11, Ремикон ХК-ийн 2025 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр зэргийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг батлах тухай

1. Ремикон ХК-ийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 7-ний өдрийн дугаар 25/1/1 тоот дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР

**РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025.04.30

№ ХЭХ-25/02

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.7, Ремикон ХК-ийн 2025 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн Ремикон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүнээр томилох тухай

1. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүнээр Х.Гантулга, Б.Батсайхан, Х.Хашчимэг, Ч.Мөнгөнсүх, Ц.Эрдэнэбаяр, Э.Мөнхсайхан нарыг, хараат бус гишүүнээр С.Баянмөнх, Д.Алтанхуяг, С. Дөлгөөн нарыг 2025 оны 4-р сарын 30-ны өдрөөс 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох хүртэл хугацаагаар тус тус томилсугай.

2. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зохих журмын дагуу цалин, хангамжийг бодож олгохыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР